



Хичээлийн сэдэв:

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ СОНГОЛТЫН ОН ЖИЛҮҮД



ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ СОНГОЛТЫН ОН ЖИЛҮҮД

ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ӨӨРЧЛӨЛТ

НИЙГМИЙН ТУЛГАМДСАН
АСУУДЛУУД





ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Өмчийн харилцааны өөрчлөлтийг шалтгаан, үр дагаврын холбоонд нь тайлбарлах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга барилаа хөгжүүлнэ.



Харьцуулан
шинжлэх


Үнэлэх,
дүгнэх

Түүхчлэх




МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг	Зах зээлийн эдийн засаг
- Дан ганц нийгмийн өмч	- Өмчийн олон хэлбэр
- Хувийн мал, хөрөнгө	- Малыг хувьчилсан, өмч хөрөнгө
- Аж ахуй, эдийн засаг	- Эрэлт, нийлүүлэлт
- Үнэ, мөнгөний бодлого	- Чөлөөт үнийн тогтолцоо
- Тэгшитгэн хуваарилах зарчим	- Хүч хөдөлмөр, ашиг орлого





МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД





МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД




1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн **олон хэвшил** бүхий эдийн засагтай байна.
2. Төр нь нийтийн болон хувийн **өмчийн аливаа хэлбэрийг** хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.
3. Өмчлөгчийн эрхийг гагцхүү **хуульд** заасан үндэслэлээр хязгаарлаж болно.
4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн **эдийн засгийг зохицуулна**.

Монгол Улсын Үндсэн хууль 5-р зүйл




МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД



- ❑ Зах зээлийн эдийн засагт шилжихэд чиглэсэн бодлогыг Д. Бямбасүрэнгийн тэргүүлсэн засгийн газар хэрэгжүүлж эхлэв.
- ❑ Энэ Засгийн газар өмч хувьчлалд гол анхаарал хандуулж, нийт хүн амдаа хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгов.
- ❑ Бага хувьчлалд 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө хамрагдсанаас малчдад 4.4 сая толгой мал хувьчлан олгожээ.
- ❑ Их хувьчлалд хамрагдах үйлдвэрийн газрын эд хөрөнгийг үнэлэх ажил үндсэндээ дуусаж, их хувьчлалд 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгө хамрагдав.



МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД



Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, тэтгэлэг болон хүн амд улсаас үзүүлдэг бусад төрлийн мөнгөн орлогыг 2 дахин нэмэгдүүлж, бүх төрлийн барааны жижиглэн худалдаалах үнэ, үйлчилгээний тарифыг мөн 2 дахин өсгөхөөр шийдвэрлэсэн.



МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД



Карт № 137979

№ Барааны нэр	1 сар		2 сар		3 сар	
	Олгосон		Олгосон		Олгосон	
	хэм-жээ	өдөр	хэм-жээ	өдөр	хэм-жээ	өдөр
1. Дээд гуриал	30	1/5	30	2/4	30	3/4
2. И гуриал	30	1/4	30	2/4	30	3/4
3. Цагаан будаа	30	1/4	30	2/4	30	3/4
4. Элсэн чихэр	30	1/10	30	2/10	30	3/10
5. Цөшгийн тос	30	1/10	30	2/10	30	3/10
6. Ургамлын тос	30	1/10	30	2/10	30	3/10
7. Архи	30	1/10	30	2/10	30	3/10
8. Эдийн савил	30	1/10	30	2/10	30	3/10
9. Угаалгын нунт	30	1/10	30	2/10	30	3/10
10. Мах	30	1/10	30	2/10	30	3/10
11. Шүдэнз	30	1/10	30	2/10	30	3/10
12. Малгоо	30	1/10	30	2/10	30	3/10
13. Сүү	30	1/10	30	2/10	30	3/10

500гр шүүмэл



Хүн амын амьдралын доод түвшинг баталгаажуулах үүднээс өдөр тутмын зайлшгүй хэрэгцээт 16 үндсэн нэрийн хүнсийг картаар олгох болж, өргөн хэрэглээний бараа, цахилгаан эрчим хүч, ус, дулаан, орон сууцны болон хотын тээврийн үйлчилгээний үнэ, тарифыг л төрөөс хянан тогтоож байв.



МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД

Улаанбаатар хот болон Ховд, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Дундговь аймгийн 1500 иргэнийг хамруулан 2016 оны гуравдугаар сарын 11-нээс 31-ний хооронд явуулжээ. Судалгаанд оролцогчид Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн хамгийн тулгамдаж байгаа асуудлын нэгдүгээрт **ажилгүйдлийг** нэрлэсэн байна. 36.3 хувь нь ажилгүйдэл хамгийн тулгамдсан асуудал гэжээ. Харин дараа **амьжиргаа** /15.1/, **эдийн засаг** /9.0/, **үнийн өсөлт** /8.0/, **боловсрол** /5.8/, **хууль хэрэгжилт** /5.7/, **авлига** /4.4/, **нийгмийн шударга ёс** /3.6/, **төрийн удирдлага** /3.0/, **уул уурхайн салбар** /2.8/ хэмээн хариулжээ.

Эх сурвалж: <https://news.mn/r/721796/>



МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД

Нийгмийн тулгамдсан асуудлуудыг нэрлэж, бичнэ үү.

Нэрлэж бичсэн асуудлуудаа чухлаас нь чухал бус руу эрэмбэлнэ үү.

Хамгийн чухал гэж үзсэн асуудлаа яагаад чухал болохыг тодорхой үндэслэлээр тайлбарлана уу.

Тухайн асуудлын шалтгаан, үр дагавар, шийдэх арга замын оновчтой хувилбарыг дэвшүүлээрэй.



МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД



НҮБ-ын цөлжилттэй
тэмцэх олон улсын
конвенцод тодорхойлсноор

*“Уур амьсгалын өөрчлөлт,
хүний үйл ажиллагаа
хавсарсан олон янзын
хүчин зүйлсийн нөлөөгөөр
хуурай, заримдаг хуурай,
хуурайвтар, чийг дутмаг
нутаг оронд газар орчин
доройтохыг цөлжилт
гэнэ.”*



МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД



Цөлжилтөд ой модны хууль бус ашиглалт, хүнд үйлдвэрүүд, хөрс хуулалт, элс, хайрга олборлолт, уул уурхайн ашиглалтын дараах нөхөн сэргээлтийг шаардлагын түвшинд хийхгүй байгаа байдал, бэлчээрийн газрын талхагдал, мал сүргийн бүтцийн тэнцвэртэй байдлын алдагдал, хөдөө орон нутгийн олон салаа зам харгуй, хөрсний бохирдол зэрэг нь газрын доройтол, цөлжилтөд нөлөөлдөг.



МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД

2015 оны 9-р сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) гишүүн 193 орны төрийн тэргүүнүүд Ерөнхий Асамблейн 70-р чуулганы үеэр “Тогтвортой Хөгжлийн Зорилгууд” (Sustainable Development Goals) хөтөлбөрийг баталсан бөгөөд 2030 он гэхэд 17 зорилго, 169 зорилтын хүрээнд дэлхийн улс орнууд өөрт тулгарсан саад бэрхшээлийг даван туулж, ирээдүйд гарч болох эрсдлээс сэргийлэх, цаашид хөгжих бололцоог төгөлдөржүүлэхийн тулд хэнийг ч ардаа үл үлдээж, хамтдаа хүчин зүтгэх болсон билээ. Тус урт хугацааны бодлогын баримт бичиг нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн үндсэн гурван хүчин зүйлд тулгуурлах ба эдгээр нь өөр хоорондоо харилцан шүтэлцээтэй байдаг.





МОНГОЛ УЛС ШИНЭ СОНГОЛТЫН ЖИЛҮҮДЭД

1 ЯДУУРЛЫГ УСТГАХ 	2 ӨЛСГӨЛӨНГ ЗОГСООХ 	3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ 	4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ 	5 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ
6 БАТАЛГААТ УНДНЫ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ 	7 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ 	8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ 	9 ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ Хөгжүүлэх 	10 ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ
11 Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих 	12 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ 	13 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ 	14 ДАЛАЙ ТЭНГИСИЙН НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ 	15 ХУУРАЙ ГАЗРЫН ЭКО СИСТЕМИЙГ ХАМГААЛАХ
16 энх тайван, шударга ёсыг цогцлоох 	17 хөгжлийн төлөөх туншлэлийг бэхжүүлэх 	 ТОГТВОРТОЙ Хөгжлийн ЗОРИЛГО		



ГЭРИЙН ДААЛГАВАР



Даалгаврын
хувилбарууд

Эрдэм шинжилгээний өгүүлэл уншиж, түүнийгээ
тайлбарлах



Тулгамдаж буй асуудлын хүрээнд бүтээлч даалгавар
хийгээрэй.



АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА.